



**БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН ЯАМ**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2017 ОНЫ 2 ДУГААР САРЫН МЭДЭЭ

НЭГ. САЛБАРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЧИГЛЭЛЭЭР:

Их дээд сургуулиудаас Боловсролын багц хуулинд оруулах саналуудыг авч, үзэл баримтлал боловсруулах ажил хийгдэж байна. БСШУ-ы сайдын 2002 оны 283-р тушаалаар баталсан “Их сургууль, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн удирдах зөвлөлийн үлгэрчилсэн дүрмийг шинэчлэн боловсруулж, БСШУС-ын сайдын 2017 оны “Үлгэрчилсэн дүрэм шинэчлэн батлах тухай” А/01 дүгээр тушаалаар батлуулан мөрдүүлж эхэллээ.

“Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-ийг боловсруулах ажлын хэсгийг дэд сайд Ё.Отгонбаяр ахлуулан шинэчлэн байгуулсан. Мөн “Хууль, тогтоомжийн хууль”-ийн дагуу урьдчилсан тандалт судалгаа болон үр нөлөөллийн судалгаа хийлгэхээр БСШУС-ын сайдын 2017 оны “Судалгааны баг байгуулах тухай А/27 дугаар тушаалаар СУИС, Монголын Урлагийн зөвлөл болон СЭЗИС-ын эрдэмтэн судлаач, багш нараас бүрдсэн судалгааны баг байгуулагдан ажиллаж байна. Энэ дагуу Судалгааны баг 11 удаагийн уулзалт хурал, зохион байгуулж, хамтарсан судалгаа хийж, сайд болон хууль боловсруулах ажлын хэсэгт судалгааны дүнг танилцуулах илтгэлийг боловсруулан бэлтгээд байна.

Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлж, дэмжүүлэн БСШУНБХ-нд шилжүүлж ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байна.

ХОЁР. САЛБАРЫН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

Ерөнхий боловсролын тусгай сургуулийн суралцагчийн Үдийн хоолны зардлын норматив тогтоох тухай тогтоолын төсөлд яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр хүргүүлээд байна.

“Цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм”-ийг шинэчлэх талаар орон нутгаас санал авч нэгтгэж байна. Мөн онцлог үйл ажиллагаатай болон хотын төвийн, захын, хувийн,

тусгай цэцэрлэгийн дүрмийн загваруудыг харьцуулан судлах ажлыг Боловсролын хүрээлэнтэй хамтран хийж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн Бэлтгэл хөтөлбөрийг боловсруулах ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрийн төслийг боловсруулан, хөдөө орон нутгийн багш, мэргэжилтнүүдээс санал авах бэлтгэлийг хангаж байна.

Боловсролын хүрээлэнтэй хамтран, болзошгүй гамшиг, ослоос өөрийгөө болон бусдыг хамгаалах чадвар эзэмшүүлэх сургалтын хөтөлбөрийн бүтэц, арга хэлбэрийг тодорхойлох уулзалтыг Онцгой байдлын газартай хамтран 3 удаа зохион байгууллаа. Энэхүү хөтөлбөрийг боловсролын хүрээлэнгийн сургалтын хөтөлбөр хариуцсан мэргэжилтнүүдийг оролцуулан боловсруулах ажлын төлөвлөгөөг боловсруулан батлахад бэлэн болоод байна.

Германы ASIIN байгууллагын Монголын дээд боловсролын байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур шаардлагад ирүүлсэн саналыг хэлэлцэн санал солилцох, Германы талтай ойлголтоо нэгтгэх, шаардлагатай асуудлуудыг тодруулах зорилгоор 1 дүгээр сарын 9 болон 13-ны өдрүүдэд онлайн хурал зохион байгуулав.

Европын холбооны Эрасмус плас (Erasmus+) төслийн санхүүжилтээр “Докторын төвшний хөтөлбөрийн чанарын баталгаажууллын тогтолцоог боловсруулах, нэвтрүүлэх” (СЗQA) төслийг Армен, Монгол, Казакстан, Украин улсуудын хамтарсан консорциумын баг хэрэгжүүлэхээр боллоо. Уг төсөлд 4 улсын Боловсрол, шинжлэх ухааны яам, чанарын баталгаажууллын үндэсний байгууллагууд, тэргүүлэх судалгааны их сургуулиуд, мөн Франц, Испани, Польшийн их сургуулиуд оролцож байна. Төслийн багийн анхны зөвлөлдөх уулзалт 2017 оны хоёрдугаар сарын 03-ны өдөр Армен улсын нийслэл Ереван хотноо болоход Монголын талаас 8 хүнтэй баг оролцож гэрээ байгууллаа.

Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хоёр дахь шатны хамтын ажиллагааны гэрээг батлууллаа. Энэ сургууль нь Монгол Улсад олон улсын стандартад нийцсэн, Германы дээд боловсрол, шинжлэх ухааны тэргүүн туршлагыг нэвтрүүлж, уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг дээшлүүлж, олон улсад өрсөлдөх чадвартай мэргэжилтнүүдийг бэлтгэх зорилготой юм. Төслийн I дүгээр шатанд сургууль байгуулах, байгууллагын бүтэц зохион байгуулалтыг төлөвшүүлэн сургалтад шаардлагатай ном, сурах бичиг болон лабораторийн зарим тоног төхөөрөмжөөр ханган МГТИС-ийн менежмент, маркетингийн үйл ажиллагаа болон логистикийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж, төслийн санхүүжилтээр тодорхой хөрөнгө оруулалтууд хийгдэн. 2016 оны 6 дугаар сард хэрэгжиж дууссан байсан. Хоёр дахь шатны гэрээ нь тус сургуулийн бие даасан тогтвортой хөгжлийг хангах, чанарын хяналтыг сайжруулах, цаашид судалгааны их сургууль болгон хөгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилготойгоор хийгдэж байгаа бөгөөд 2019 оны 6 дугаар сар хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна. 2019 онд төсөл хэрэгжиж дуусахад тус сургууль нь Европын стандартад нийцсэн инженерийн боловсон хүчнийг Монголд бэлтгэдэг хүний нөөцийн болон дэд бүтцийн цогц систем бүхий судалгааны их сургуулийн болон хөгжих суурь тавигдах юм.

БСШУС-ын сайдын 2016 оны “Ажлын хэсэг шинэчлэн батлах тухай” А/122 тоот тушаалаар соёлын статистикийн маягт үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг шинэчлэгдэн байгуулагдсан. Соёл, урлагийн салбарын статистик мэдээллийн үзүүлэлт маягт болох СУ-1-ээс СУ-17 хүртэлх маягт нь анх 2003 онд батлагдсанаас хойш дахин шинэчлэгдээгүй бөгөөд үндсэн 17 маягтын 55 үзүүлэлтийг шинэчлэн боловсрууллаа. Статистикийн маягтыг шинэчлэхдээ Соёлын өвийг хамгаалах тухай хууль болон Номын сангийн тухай хуульд нийцүүлэн бодлого боловсруулахад шаардлагатай тоон мэдээллийг цуглуулах зорилгоор хуучин ашиглаж байсан маягтад шинэ үзүүлэлт тусгах болон шинээр маягт хүснэгтийг нэмж боловсруулах замаар нийт 29 маягтыг 200 гаруй үзүүлэлтээр нэмж баяжуулан Үндэсний статистикийн хороонд хүргүүлээд байна.

Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд баталж мөрдүүлэхээр туссан “Соёлын өвийн үзлэг тооллого хийх журам”, “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх журам”, “Соёлын өвийг хувилан олшруулах, хуулбарлах, бүтээгдэхүүний загварт оруулах, кино, дүрс бичлэг хийх, гэрэл зураг авах, марк, ил захидал, цомог хийх журам”-ын төслүүдийг боловсруулах ажлын хэсгийг сайдын 2017 оны А/46 дугаар тушаалаар, мөн “Чулуун соёлын өв хөтөлбөр”, “Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн төслүүдийг боловсруулах ажлын хэсгийг сайдын 2017 оны А/53 дугаар тушаалаар байгуулсан. Төслүүдийг эхний улиралд боловсруулж батлуулахаар холбогдох арга хэмжээг авч байна.

"Төрөөс Шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого"-ын төслийг 2017 оны I улиралд багтаан боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр холбогдох зохицуулалтыг хийж байна.

Спортын 7 төрлөөр орчны болон сургалтад тавих стандартыг боловсруулах ажлын хэсгийг БТСГ-т байгуулж эхний хурлыг хийж дэд ажлын хэсгүүдэд тодорхой даалгавар өгч ажиллаж байна.

ГУРАВ. САЛБАРЫН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:

Боловсролын дэлхийн чуулган, ЮНЕСКО-гийн 38 дугаар Ерөнхий чуулганаас баталсан Инчоны тунхаглал, “Тогтвортой хөгжлийн зорилт 4-хэрэгжүүлэх Боловсрол 2030” үйл ажиллагааны хүрээ” баримт бичгийг англи хэлнээс монгол хэлээр орчуулсан орчуулгыг хянан хэвлүүлж түгээж эхэллээ.

Дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд “Дээд боловсролын шинэчлэл” олон улсын зөвлөх үйлчилгээний төслийн хэрэгжилт, бүтээгдэхүүн танилцуулах уулзалт, семинарыг зохион байгуулж, “Дээд боловсролын шинэчлэл” олон улсын зөвлөх үйлчилгээний бүтээгдэхүүнийг хүлээн авах, танилцуулах ажлыг хийж, гадаад 6, үндэсний 10 зөвлөх, төсөлд хамрагдсан 4 сургууль мэдээлэл хийлээ.

Хүсэлт гаргасан 33 их, дээд сургуульд боловсролын баримт бичгийн нийт 5,200 дугаар олгов (дипломын 78, бакалаврын 3472, магистрын 1604, докторын 45)

Монгол Улсын боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Унгар улсын хүний нөөцийн яам хоорондын Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт 2015-2017 онд хамтран ажиллах Хамтын ажиллагааны хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулах баримт бичгийг 2017 оны 02 дугаар 09-ний өдөр байгуулсан. Баримт бичигт Монголын талыг төлөөлж БСШУС-ын сайд Ж.Батсуурь, Унгар талаас Унгарын Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Мадари Акош нар гарын үсэг зурсан. Хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулснаар Монгол Улсаас Унгар Улсын Засгийн газрын тэтгэлгээр 200 хүртэлх монгол иргэнийг суралцуулахаар болж байна. Нэмэлт өөрчлөлтийн хүрээнд бакалаврт 70, магистрантурт 75, докторантурт 30 хүн суралцана. Түүнчлэн 15 иргэнийг богино хугацааны сургалтад хамруулахаар боллоо. Манай иргэд Унгар Улсад хөдөө аж ахуй, нийгмийн ухаан, мэдээлэл зүй, хууль эрх зүй, эдийн засаг, инженер, анагаах ухаан, арга зүй, байгалийн шинжлэх ухаан, соёл урлаг зэрэг мэргэжлээр суралцана.

Монгол Улсын БСШУСЯ, БНБеларусь Улсын Соёлын яам хооронд соёлын салбарт хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг 2017 оны 02 дугаар сарын 06-ний өдөр хэлэлцээрийг байгуулсан. Хэлэлцээрт Монголын талаас БСШУС-ын сайд Ж.Батсуурь, Беларусийн талаас БНБеларусь Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд С.В.Чепурной нар гарын үсэг зурсан. Энэхүү хэлэлцээр нь хоёр орны соёлын салбарт байгуулсан анхны баримт бичиг юм. Хэлэлцээрийг байгуулснаар манай хоёр орны соёл, урлагийн байгууллага, тухайлбал, театр, музей, кино, хөгжим, бүжиг, зураг урлан, номын сан, соёл урлагийн сургууль хоорондын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой боллоо. Талууд түүх соёлын өв, дурсгалыг сэргээн засварлах чиглэлээр туршлага, мэдээллийг харилцан солилцож, шинжээч, мэргэжилтэн ажиллуулахаар тохирсон.

2014 онд Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улсыг хилээр хууль бусаар нэвтрүүлсэн палеонтологийн 11 нэр төрлийн олдворыг Бүгд Найрамдах Солонгос Улсын хууль сахиулагчид хураан авч, хэрэг үүсгэн шалган шүүхээр эцэслэн шийдвэрлүүлсэн. Монгол Улсын Ерөнхий Прокурорын газар, Солонгосын Дээд прокурорын газрын хамтын ажиллагааны хүрээнд олдворыг хүлээж авах ажлыг зохион байгуулав. Олдворыг тус улсад бүрэн боловсруулалт хийж үзэсгэлэн гаргахаар хоёр талын холбогдох байгууллагууд ажиллаж байна.

Монголын Хөгжмийн Зохиолчдын Холбооноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг оны шилдэг дуу шалгаруулах “Морин хуур-2016” наадмын 30 жилийн ойн тохиож байгааг тохиолдуулан дэмжлэг үзүүлж, хамтран ажиллаа. “Морин хуур” 2016 наадам 2017 оны 1 сарын 16-28-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо ажмилттай зохион байгуулагдлаа. Энэ жилийн наадамд хөгжмийн зохиолч Ш.Өлзийбаярын “Тэнэгэр их тал” уран бүтээл Гран при шагнал хүртэж, 1 дүгээр байрт Т.Сэр-Одын хөгжим “Гэгээн нутаг” дуу, 2 дугаар байранд ш.Сугарцэрэнгийн хөгжим “Аавтай орчлон” дуу, 3 дугаар байрт Б.Бямбабаярын хөгжим “Ийм л сайхан” дуу, тусгай байрын шагналд 4 зохиолчийн уран бүтээл тус тус шалгарсан байна.

2017 оноос шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтыг үе шаттай зохион байгуулж байна.

- ▶ 2017 оноос эхлэн хэрэгжүүлэх Тэргүүлэх чиглэл, цөм технологийн төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах бэлтгэл ажил хангагдаж байна. Одоогоор салбар яамдуудаас нийт 101 арга хэмжээний болон цөм технологийн төслийн санал ирээд байна.

- ▶ 2017 оноос эхлэн хэрэгжүүлэх захиалгат төслийн саналыг 2016 оны 01 дүгээр сарын 05-ны дотор ирүүлэх тухай 1а/4490 дугаар бүхий албан бичгийг яамдад хүргүүлж ирүүлсэн төслийн саналыг Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн гишүүдэд танилцуулаад байна.
- ▶ 2017 оноос эхлэн хэрэгжүүлэх инновацийн төслийн сонгон шалгаруулалтыг олон нийтийн хэвлэл мэдээллээр нээлттэй зарлаж, цахим хаягаар (<http://www.project.edu.mn/>) хүлээн авлаа. Нийт 200 гаруй төсөл бүртгэгдээд байна.
- ▶ 2017 оноос эхлэн хэрэгжүүлэх суурь судалгааны төсөлд нийт 246 төслийн саналыг хүлээн авч шинжлэх ухааны 6 салбараар ангилан, мэргэжлийн шинжээч томилон уншуулж, дүгнэлт гаргуулсан. Шинжээчийн дүгнэлтээр тэнцсэн төслүүдийг Шинжлэх ухаан, технологийн салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд бэлэн болоод байна.
- ▶ 2016 онд сонгон шалгаруулсан Хятадтай хамтарсан 5 төслийн удирдагч нар, ШУТСангийн удирдлагатай хамтарсан хурал зохион байгуулж, гэрээ байгуулахад шаардлагатай үр дүнгийн даалгавар, ажлын календачилсан төлөвлөгөө, санхүүгийн тооцооллыг танилцууллаа. 2017 оны санхүүжилтийн саналыг гаргуулахаар ШУТСанд хүргүүлж сайдын тушаалаар баталгаажуулахаар ажиллаж байна. Мөн 2017 оноос шинээр хэрэгжүүлэх хамтарсан төслийг зарлах бэлтгэл ажлыг ханган ажиллав.
- ▶ 2017 оноос Солонгостой хамтран хэрэгжүүлэх төслийн саналыг онлайнаар хүлээн авч дууслаа. 2017 онд мэдээллийн технологи, био нөөцийн ашиглалтаар хамтарсан төсөл хэрэгжүүлэхээр тохиролцсоны дагуу нийт 20 хүлээн авлаа.
- ▶ 2017 оноос ОХУ-ын Хүмүүнлэгийн шинжлэх ухааны сантай хамтран хэрэгжүүлэх төслүүдийн 27 саналыг оросын талтай солилцож, төслүүдэд шинжээчдийн санал гаргуулах ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна

Салбарын мэдээллийн портал www.sport.gov.mn цахим хуудсыг өргөжүүлж спортын холбоо, аймаг, нийслэлийн үйл ажиллагааны мэдээлэл нэгтгэх ажил үргэлжилж байна. Улсын хэмжээнд анх удаа хийгдэх Статистикийн Улсын тооллогын бэлтгэл ажлыг хангах ажил хийгдэж байна. БТСГ-т спортын “data base”-ийн мэдээлэл, мэдээллийн урсгал, зураглал гаргах ажлын хэсэг байгуулагдсан

ДӨРӨВ. САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

Азийн хөгжлийн банкны “Сургууль, цэцэрлэгт олгох тусламжийн санал солилцоо”-ны хүрээнд Улаанбаатар хотод хэрэгжүүлэх шаардлагатай 50 цэцэрлэг, 32 сургуулийн жагсаалтыг Нийслэлийн боловсролын газраас хүлээн авч нягтлан шалгаж,

танилцуулав. Азийн хөгжлийн банкнаас 80 гаруй тэрбум төгрөгийн тусламж үзүүлэх яриа хэлэлцээр явагдаж байгаа болно.

Япон улсын буцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн 150 ортой сургалтын эмнэлгийн барилга угсралтын ажилтай танилцсан. Монголын талаас хийх шаардлагатай ажлын зураг төсөв хийгдэж байна

Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт 2017 онд авч хэрэгжүүлэх 23 арга хэмжээнд 987 сая төгрөгийг тусгасан “Зардал батлах тухай” БСШУС –ын сайдын А/60 дугаар тушаалыг ШУТСанд хүргүүлсэн.

ТАВ. ДОТООД АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Ерөнхий боловсролын лаборатори 44 сургууль, төрийн өмчийн их, дээд сургуулийн захирлын 2016 оны үр дүнгийн гэрээг үнэлж дүгнэсэн бөгөөд 2017 оны үр дүнгийн гэрээ боловсруулах чиглэлийг тодорхойлж, лаборатори сургуулийн захирлуудад хүргүүлсэн.

Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын яам болон харьяа байгууллагуудаас 2016 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг 2 дугаар сарын 15-ны дотор буюу хуулийн хугацаанд бүрэн гаргуулан авсан. Нийт 581 мэдүүлэг гаргагчийн Хөрөнгө орлогын мэдүүлгийг холбогдох журмын дугуу гаргуулан авч баталгаажуулсан.

Одоо ХАСХОМ 1, ХАСХОМ 2 тайланг гаргахаар ажиллаж байна.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН ЯАМ